



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИГУУЛАГЧ АГЕНЦИАГ
ШУДАРГА ОРСОЛДООН,
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР

Засгийн газрын XII байр, Барилагчдын талбай 13,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41,
Цахим шуудан: contact@afccp.gov.mn,
Цахмь хуудас: www.afccp.gov.mn

2024.02.15 № 01/218

Танай _____-ны № _____-т

Тендерийн баримт бичгийг
хянасан тухай

Танай компаниас зарласан “Зүтгүүрийн сэлбэг, хэрэгсэл” МТЗ/20240102152 дугаартай тендерийн баримт бичигт холбогдох гомдлыг “Альфа Филтер” ХХК-аас тус газарт ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хянан үзлээ.

Тендерийн баримт бичгийн техникийн тодорхойлолт сэлбэгийн нэрт 150 төрлийн бараа бүтээгдэхүүнийг дурдсан бөгөөд үүнээс 10 гаруй нэр төрлийг гомдол гаргагч аж ахуй эрхлэгч дотоодод үйлдвэрлэх боломжтой байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т “Дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой чанар, стандартын шаардлага хангасан барааг дотоодын үйлдвэрээс худалдан авахаар тендер шалгаруулалтын баримт бичигт заана.” гэж, 8.2-т “Энэ хуулийн 8.1-д заасан барааны нэр, төрлийн жагсаалтыг эдийн засаг, хөгжлийн, хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран боловсруулж, Засгийн газар батална” гэж заасан байна. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 90 дугаар тогтоолоор баталсан “Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай барааны жагсаалт”-ын 14.8-т “Тоос, тоосонцор, хий, утаа шүүх, цэвэрлэх тоног төхөөрөмж, агаар шүүгч, тээврийн хэрэгслийн бүх төрлийн шүүлтүүр, тэдгээрийн сэлбэг эд, анги” гэж заасан байна.


“Зүтгүүрийн сэлбэг, хэрэгсэл” МТЗ/20240102152 дугаартай тендер шалгаруулалалтын үнэлгээний хорооны 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хурлын тэмдэглэлд “...Монгол улсын засгийн газрын 2019 оны 90 дүгээр тогтоол, жагсаалт батлах тухай 336 дугаар тогтоолын хавсралтын 14.8-д “Тоос, тоосонцор, хий, утаа шүүх, цэвэрлэх тоног төхөөрөмж, агаар шүүгч, тээврийн хэрэгслийн бүх төрлийн шүүлтүүр, тэдгээрийн сэлбэг, эд анги”-ийг дотоодын үйлдвэрлэгчээс худалдан авч болох тухай зохицуулалт байна. Гэхдээ зүтгүүрийн сэлбэг, хэрэгсэл нь өөр хоорондоо уялдаа холбоотой байдаг тул цугт нь зарлах нь зөв байх гэж үзэж байна. Хууль тогтоомжийн нийцэл нь яах вэ?... Дотоодын үйлдвэрлэгч нар оролцох эрх нь бол нээлттэй хэвээрээ. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5, 8.6, 8.7 дахь хэсэгт заасны дагуу үнэлэхдээ шийдвэрлэж болно...Тийм учраас Төрийн болон орон нутгийн өмчийн

хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5, 8.6, 8.7 дахь хэсэгт заасны дагуу үнэлнэ...” гэж тэмдэглэсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-т “Оролцогч ажил гүйцэтгэхэд дотоодын бараа ашиглахаар санал болговол давуу эрх олгоно” гэж заасан байна. Мөн тус тендер шалгаруулалтын үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлд “зүтгүүрийн сэлбэг, хэрэгсэл нь өөр хоорондоо уялдаа холбоотой байдаг тул цугт нь зарлах нь зөв” гэж, “дотоодын үйлдвэрлэгч нар оролцох эрх нь бол нээлттэй хэвээрээ. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5, 8.6, 8.7 дахь хэсэгт заасны дагуу үнэлэхдээ шийдвэрлэж болно” гэж тус тус дурдсан байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой... хариуцлагатай байх зарчмыг баримтална” гэж заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байх тул тус тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулахыг үүгээр мэдэгдэж байна.

ДАРГА



Б.БИЛГҮҮН